

## **НҮҮРСНИЙ АРИЛЖААНЫ ТУРШИЛТЫГ ЭХЛҮҮЛНЭ**

Нүүрсний дуудлага арилжааны системд оролцогч талуудыг хамруулсан туршилтын арилжааг эхлүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12-р сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолоор батлагдсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын хэрэгжилтийг хангах үүднээс МХБ нь “Экспортод гаргах нүүрсний арилжааг зохион байгуулах заавар”-ыг боловсруулан батлуулах, арилжааны системийг бэлэн байдлыг хангах, оролцогч байгууллагуудтай гэрээ байгуулах, сургалт, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах, арилжаанд оролцох гарын авлага болон бусад мэдээлийг хүргүүлэх зэрэг холбогдох бэлтгэл ажлуудыг хангахаар ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд нүүрсний арилжаанд оролцогч талууд болох нүүрс худалдах болон худалдан авах сонирхол бүхий этгээдүүдийг оролцуулсан арилжааны туршилт хийх, төлбөрийн шилжүүлэг хийхтэй холбоотой туршилтын ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ